



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/87/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 260512 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Утас: 326275 Цахим хаяг: enkhtuya@hlb.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	17
8.3 Албан шаардлага	17
8.4 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОШХ	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
ДДХ	Дунд даралтын хэсэг
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭХ	Дулааны эрчим хүч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОХУ	Оросын холбооны улс
ӨДХ	Өндөр даралтын хэсэг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ЦЭХ	Цахилгааны эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

2022.03.15 № 07/557
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцлох хэсэг

Улаанбаатар хотын цахилгаан, дулаан хангамжийн 5 дахь эх үүсвэрийг 3 дугаар цахилгаан станцын дэд бүтцэд түшиглэн барих төсөл нь 2021 онд ОХУ-ын "Интер Рао Экспорт" ХК-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Төслийн Техник эдийн засгийн үзүүлэлтийг уг компани гүйцэтгэж байгаа бөгөөд Өндөр даралтын хэсгийг 250МВт-р өргөтгөх, Дунд даралтын хэсгийг 250МВт-р шинэчлэх төслийн ажлын даалгаврыг боловсруулж гүйцэтгэгч талд хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 118,992.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 122,467.1 сая төгрөгөөр, алдагдлыг 3,474.8 сая төгрөг байхаар баталсан байна. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2021 оны А/187, А/230 дугаар тушаалаар 1,312.6 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 128,984.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 128,960.2 сая төгрөгийн зардал гарган, 24.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани нь 2021 онд 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 97.5 хувьтай гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,032,067,503.81	2,750,076,012.74
1.1.2	Дансны авлага	8,716,333,194.71	14,841,687,708.01
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	884,576,943.16	1,574,099,298.18
1.1.4	Бусад авлага	112,954,376.04	63,973,289.26
1.1.6	Бараа материал	9,377,755,907.41	10,947,076,483.70
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,081,654,837.87	442,014,372.09
1.1.8	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,205,342,763.00	30,618,927,163.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	225,691,789,215.15	229,004,522,146.70
1.2.2	Биет бус хөрөнгө	39,095,674,558.29	39,033,550,917.63
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765,158.10	204,765,158.10
1.2.4	Дуусаагүй барилга	12,782,891,481.37	69,365,352.44
1.2.5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	277,775,120,412.91	268,312,203,574.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	298,980,463,175.91	298,931,130,738.85
2	Эргэлтийн бус хөрөнгө		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,187,454,985.45	8,651,931,665.23
2.1.1.2	Цалингийн өглөг	2,928,119,070.41	2,826,977,622.19
2.1.1.3	Татварын өр	148,945,708.01	471,451,618.54
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	5,778,140,808.52	848,662,419.30
2.1.1.6	Хүүний өглөг	150,742,884.82	146,117,140.93
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	276,688,532.39	7,670,925.70
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	294,343,970.55	199,133,594.36
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,764,435,960.15	13,151,944,986.25
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	15,267,147,247.34	13,489,006,739.89
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,720,580,852.10	1,396,255,734.58
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,741,954,627.03	2,365,960,064.18
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	19,729,682,726.47	17,251,222,538.65
2.2	Өр төлбөрийн нийт дүн	30,494,118,686.62	30,403,167,524.90
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч:-төрийн	99,362,782,973.56	99,362,782,973.56
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	158,066,844,148.39	157,971,926,506.86
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	38,753,450,000.00	38,753,450,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(27,696,732,632.66)	(27,560,196,266.47)
2.3.5	Эздийн өмчийн дүн	268,486,344,489.29	268,527,963,213.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	298,980,463,175.91	298,931,130,738.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	122,038,838,341.61	128,421,637,338.54
2	Борлуулалтын өртөг	113,936,670,331.16	118,184,413,802.04
3	Нийт ашиг (алдагдал)	8,102,168,010.45	10,237,223,536.50
4	Түрээсийн орлого	105,148,689.21	88,972,426.94
5	Хүүний орлого	52,710,382.88	5,884,435.40
6	Бусад орлого	515,458,891.83	468,273,981.31
7	Борлуулалт маркетингийн зардал	195,737,183.91	197,666,130.67
8	Ерөнхий ба удирдлагын зардал	7,677,493,532.73	7,683,270,678.56
9	Санхүүгийн зардал	694,858,829.04	515,611,935.43
10	Бусад зардал	2,279,024,722.15	2,379,253,549.33
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	23,524,922.36	(1,489.97)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(21,331,342.90)	
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,069,434,714.00)	24,550,596.19
14	Орлогын татварын зардал	38,174,796.18	588,443.53
15	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,107,609,510.18)	23,962,152.66
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,107,609,510.18)	23,962,152.66

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,973.56	109,442,769,310.97	38,694,650,000.00	(25,869,711,842.34)	221,630,490,442.19
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				280,588,719.86	280,588,719.86
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	109,442,769,310.97	38,694,650,000.00	(25,589,123,122.48)	221,911,079,162.05
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,107,609,510.18)	(2,107,609,510.18)
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг			58,800,000.00		58,800,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		48,624,074,837.42			48,624,074,837.42
2020 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	99,362,782,973.56	158,066,844,148.39	38,753,450,000.00	(27,696,732,632.66)	268,486,344,489.29
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				112,574,213.53	112,574,213.53
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	158,066,844,148.39	38,753,450,000.00	(27,584,158,419.13)	268,598,918,702.82
Тайлант үеийн цэвэр				23,962,152.66	23,962,152.66

ашиг (алдагдал)					
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(94,917,641.53)			(94,917,641.53)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,753,450,000.00	(27,560,196,266.47)	268,527,963,213.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	124,131,048,440.71	125,404,661,630.65
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	123,806,909,457.74	124,902,279,626.83
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	204,968,190.00	304,022,084.70
1.1.6	Бусад мөнгөн орлого	119,170,792.97	198,359,919.12
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	111,375,816,016.64	111,885,707,308.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	21,875,811,453.73	23,611,647,504.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,172,061,337.17	7,892,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	60,570,547,638.23	59,690,029,895.43
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,195,818,211.29	1,611,968,188.60
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,975,724,091.76	6,457,599,056.76
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	401,839,403.94	201,049,227.37
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	8,401,826,478.19	10,212,859,623.40
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	76,839,876.00	51,407,994.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,705,347,526.33	2,157,145,818.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,755,232,424.07	13,518,954,322.42
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	52,710,382.88	5,884,435.40
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	52,710,382.88	5,884,435.40
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,715,097,099.23	7,541,069,861.43
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,715,097,099.23	7,541,069,861.43
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,662,386,716.35)	(7,535,185,426.03)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,000,000,000.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,000,000,000.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,213,415,199.46	4,265,760,387.46
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,213,415,199.46	4,265,760,387.46
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,786,584,800.54	(4,265,760,387.46)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(120,569,491.74)	1,718,008,508.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,152,636,995.55	1,032,067,503.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,032,067,503.81	2,750,076,012.74

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү төлөвлөснөөс	Хувь	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	мян.квтц	1,050,077.8	1,034,472.0	1,109,235.6	74,763.6	7.2	
	ДХЦЭХ	хувь	16.86	17.11	16.37	(0.7)	(4.3)	
		мян.квтц	177,085.2	176,995.0	181,625.8	4,630.8	2.6	
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	мян.квтц	872,992.6	857,477.0	927,609.9	70,132.9	8.2
		ДЭХ	Гкал	2,369,375.0	2,436,458.0	2,466,894.0	30,436.0	1.2
	Үнийн дүнгээр	ЦЭХ	мян.төг	94,778,424.3	87,008,024.5	97,591,175.7	10,583,151.2	12.2
ДЭХ		мян.төг	27,260,414.0	31,391,513.5	30,830,461.6	(561,051.9)	(1.8)	
2	Нийт орлого	мян.төг	122,738,450.6	118,992,336.9	128,984,772.9	9,992,436.0	8.4	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	122,038,838.3	118,399,538.0	128,421,637.3	10,022,099.3	8.5	
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	699,612.3	592,798.9	563,135.6	(29,663.3)	(5.0)	
3	Нийт зардал	мян.төг	124,807,885.3	122,467,100.0	128,960,222.3	6,493,122.3	5.3	
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	336,476.8	337,651.1	342,548.5	4,897.4	1.5	
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	829,058.1	618,264.5	749,698.8	131,434.3	21.3	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал-/	мян.төг	(2,069,434.7)	(3,474,763.1)	24,550.6	3,499,313.7	(100.7)	
5	Цэвэр ашиг /алдагдал-/	мян.төг	(2,107,609.5)	(3,474,763.1)	23,962.2	3,498,725.3	(100.7)	
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.02	1.03	1.00	(0.03)	(2.9)	
7	Нийт авлага	мян.төг	9,713,864.5	7,302,300.0	16,479,760.3	9,177,460.3	125.7	
8	Нийт өглөг	мян.төг	30,494,118.6	29,451,800.0	30,403,167.5	951,367.5	3.2	
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	10,764,435.9	11,749,000.0	13,151,945.0	1,402,945.0	11.9	
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	19,729,682.7	17,702,800.0	17,251,222.5	(451,577.5)	(2.6)	
9	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	мян.төг	21,326,325.2	14,478,969.2	14,195,751.4	(283,217.8)	(2.0)	
10	Нийт ажиллагсдын тоо	хүн	995.0	996.0	989.0	(7.0)	(0.7)	
11	Нийт цалингийн сан	мян.төг	28,432,106.2	28,064,534.9	27,921,314.9	(143,220.0)	(0.5)	
12	Нэг ажиллагчийн дундаж цалин	төг	2,381,248.4	2,348,103.7	2,352,655.5	4,551.8	0.2	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын бүртгэлийг цаг хугацаанд нь бүртгэх, анхан шатны баримтыг зөв үйлдэх, хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Гажидмаа, аудитор П.Ганчимэг, Ө.Батчимэг, аудиторын туслах Д.Ариунаа, А.Отгонсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Ариундалай, захирал Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/173 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч баримт бичигт найдваргүй авлагын нөөц байгуулах, үндсэн хөрөнгийн засварын зардлыг их засвар болон урсгал засвар гэж ангилан тусад нь бүртгэх, үндсэн хөрөнгийн өртөг, капиталжуулах зардал, элэгдлийн тооцооллын талаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар гэж тусгай хэлтэс байхгүй, дотоод аудиторын орон тооны ажилтан тэтгэвэрт гарч ажлаас чөлөөлөгдсөний дараа уг орон тоонд дотоод аудитор томилогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 10,906.6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 54.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад 2021 оны санхүүгийн тайлан дахь суурь үзүүлэлтээс тооцоход 590.3 сая төгрөгийн зөрүү үүссэн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатны ерөнхий материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 128,960.8 сая төгрөгөөс 0.5 хувиар 386.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн зорилго нь тодорхой үйлчилгээ явуулах нутаг дэвсгэртээ хэрэглэгчийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай бүрэн хангах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил үйлчилгээ үзүүлнэ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, ТӨБЗГ 30.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор 100 хувийн төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-өөс, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76.1.8 “компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;”, 59 дүгээр зүйлийн 59.1 “Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэсэн заалттай нийцэж байна

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сарын цалин 0.8 сая төгрөг байгаа нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой

хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн системийг ДЦС-3-ийн Эйбл системтэй холбож, төрийн бүх байгууллагатай цахимаар албан бичиг солилцох боломж үүссэн. Компанийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа баримт бичгүүдийг нэр төрлөөр нь ангилан, кодлож ISO 9001 стандартын хүрээнд баримт бичгийн нэгдсэн сан үүсгэж баримт бичгийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар мэдээллийг цаг тухайд нь холбогдох ажилтнуудад мэдээлэх, хүчингүй болсон баримт бичгийг ашиглахаас сэргийлэх, өөрчлөгдсөн мэдээллүүдийг бүрэн хянах боломжийг бүрдүүлсэн. ISO 9001 стандарттай бүтээмжийн “Ажлын соёл 5С”, “Кайзен саналын тогтолцоо”, “Чанарын дугуйлан” зэрэг хөдөлгөөнийг хослуулсан өрнүүлж ажилласнаар нийт ажилтнуудын оролцоог дэмжих, байнгын сайжруулалтын соёлыг хөгжүүлэх, хамгийн бага зардлаар бүтээмжээ сайжруулах талаар арга хэмжээ авч ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 989 болгон бууруулж, 7 орон тоогоор хэмнэж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дугаар тушаал;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,032.1	2,750.1	1,718.0
Авлага	9,713.8	16,479.7	6,765.9
Урьдчилгаа	1,081.6	442.0	(639.6)
Бараа материал	9,377.8	10,947.1	1,569.3
Үндсэн хөрөнгө	225,691.8	229,004.5	3,312.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө	204.8	204.8	-
Биет бус хөрөнгө	39,095.7	39,033.5	(62.2)
Дуусаагүй барилга	12,782.9	69.4	(12,713.5)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Нийт хөрөнгийн дүн	298,980.5	298,931.1	(49.4)
Өр төлбөрийн дүн	30,494.1	30,403.1	(91.0)
Богино хугацаат өглөг	10,764.4	13,151.9	2,387.5
Урт хугацаат өглөг	19,729.7	17,251.2	(2,478.5)
Эздийн өмч	268,486.4	268,528.0	41.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	298,980.5	298,931.1	(49.4)

Касс дахь бэлэн мөнгө валютаар 606 ам.доллар /1.7 сая төгрөг/, төгрөгөөр 4.7 сая , банк дахь харилцах дансанд байгаа 2,743.7 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 1,566.6 сая төгрөг, НДШ-ийн авлага 4.8 сая төгрөг, ХХОАТ-ийн авлага 2.6 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Тайлант онд ДҮТ ТӨХК-аас авах борлуулалтын авлага нэмэгдэж, үлдэгдлийн өсөлтөд нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 7,520.6 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 8,959.1 сая төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагыг шууд аргаар тооцдог байна.

Урьдчилж төлсөн зардал дансны эхний үлдэгдэл 1,081.6 сая төгрөгөөс тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 813.7 сая төгрөгийг хөрөнгөнд, 43.4 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант оны Төслийн нэгж 75МВт төслийн үйл ажиллагаанд зарцуулсан 305.7 сая, мэдээллийн хэрэгслийн үйлчилгээний урьдчилгаа 10.2 сая, Улаанбаатар төмөр замд төлсөн 49.9 сая, ээлжийн амралтын урьдчилгаа 2.7 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,947.1 сая төгрөг болж 1,569.3 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний нөөцийг 1,032.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, зарим сэлбэг хил хаагдсантай холбоотойгоор хугацаанаасаа хойш нийлүүлэгдсэн 660.9 сая төгрөгийн сэлбэг материалын үлдэгдлээс шалтгаалжээ.

Азийн хөгжлийн банкны зээлээр хийгдсэн зуухыг Багануурын нүүрсэнд тохируулан шинэчлэх ажлын хүрээнд гүйцэтгэгч компаниас 9-р зуухны шинэчлэлийн ажлыг дуусгаагүй, 1,059.6 сая төгрөгийн материал үлдэгдэлд бүртгэлтэй байна. Мөн оны эцэст 44.1 сая төгрөгийн дизель түлшний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 15,301.4 сая төгрөгийн хөрөнгө, дуусаагүй барилга, их засварын капиталжуулалтын дүн 11,621.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 10/27 дүгээр тогтоолоор акталсан 1,334.5 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагджээ.

Бусад эргэлтийн бус хөрөнгийн дансанд 204.8 сая төгрөгийн судалгааны ажил бүртгэлтэй байна.

Биет бус хөрөнгө худалдаж авсан программ, ажлын зургийн төсвийн дүн 55.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 10/27 дүгээр тогтоолоор акталсан 21.2 сая төгрөгийн биет бус хөрөнгийн дүн болон 117.5 сая төгрөгийн хорогдлын дүнгээр буурчээ.

Дуусаагүй барилга данснаас 12,713.5 сая төгрөгийн үнсэн сангийн байгууламжийг бүрэн дуусгаж ашиглалтад оруулснаар хасагдаж, үнсэн сангийн усыг цэвэршүүлэх 150 тн/ц

бүтээмжтэй ус цэвэршүүлэх байгууламжийн 69.4 сая төгрөгийн ажил үлдэгдэлд бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 13,151.9 сая төгрөгийн өр төлбөр нь Бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх 8,651.9 сая төгрөг, цалингийн өглөг 2,827.0 сая төгрөг, татварын өр 471.4 сая төгрөг, богино хугацаат зээлийн өглөг 848.7 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 146.1 сая төгрөг, урьдчилж орсон борлуулалтын орлого 7.7 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 199.1 сая төгрөг тус тус байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 1996 оноос хойш Азийн хөгжлийн банк, Нордикийн хөгжлийн сангийн дамжуулан зээлдэх гэрээгээр хийгдсэн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, 2005 оноос Германы Сэргээн Босголтын Зээлийн банкнаас “Эрчим хүчний салбарын хөтөлбөр-1” төслийн хүрээнд “Төвийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн систем”-д дамжуулах сүлжээний 33 дэд станц болон ДЦС-уудын 255 тоолуурыг холбох ажилд зарцуулагдсан зээлийн 14,299.9 сая, хойшлогдсон татварын өр 1,396.3 сая, Чехийн тусламжийн хөрөнгөөр хийгдсэн түлш дамжуулах цехийн удирдлагын системийн автоматжуулалтын ажлын хойшлогдсон орлого 1,555.0 сая, нийт урт хугацаат өр төлбөрийн 17,251.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, санхүүгийн зардал гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 4,152.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ЦЭХ-ний түгээлт 54.6 сая квтц-аар, ДЭХ-ний түгээлт 97.5 мянган Гкал-аар нэмэгдсэн нь тус тус шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл тус бүрээр гарсан зардлуудыг хамруулсан байна.

НБББББ-т зардлыг компанийн үйл ажиллагаанаас хамааруулан үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны зардал, өртгийн объектод хамаарах байдлаар нь шууд болон шууд бус зардал гэж ангилж үзнэ гэж заасан нь НББОУС 1-ийн 103 “...зардлуудыг тэдгээрийн чиг үүргийн дагуу борлуулалтын өртгийн нэг хэсэг байдлаар, тухайлбал, хуваарилалтын буюу удирдлагын үйл ажиллагааны зардал байдлаар ангилдаг. Энэхүү аргын дагуу аж ахуйн нэгж наад зах нь өөрийн борлуулалтын өртгийг бусад зардлуудаас тусдаа толилуулна заалттай нийцэж байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 118,992.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 122,467.1 сая төгрөгөөр, алдагдлыг 3,474.8 сая төгрөг байхаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 13,166.4 сая төгрөгийг төлөвлөжээ. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/187 дүгээр тушаалаар 309.6 сая, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/230 дугаар тушаалаар 1,003.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 128,984.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 128,960.2 сая төгрөгийн зардал гарган, 24.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 9,992.4 сая төгрөг буюу 8.4 хувиар давсан нь ЦЭХ, ДЭХ-ний түгээлт болон чадлын тариф нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үйл ажиллагааны орлого COVID-19 цар тахлын нөлөөгөөр вагон таталт тавилтын орлого 18.3 сая төгрөгөөр, түрээсийн орлого 11.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 128,960.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6,493.1 сая төгрөг буюу 5.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь нь үйлдвэрлэлийн түгээлт нэмэгдсэнтэй холбоотойгоор түлшний зардал 4,071.5 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотойгоор элэгдлийн зардал 3,045.8 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын 2021-2022 оны өвлийн бэлтгэл хангах хүрээнд 5 үндсэн тоноглолд их засвар, 2 үндсэн тоноглолд дунд засвар, 117 туслах тоноглолд их засварын ажил хийхээр төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 116 тоноглолын их засварын ажилд өөрийн эх үүсвэрээс 14,195.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

Тайлант онд цэвэр ашиг 24.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,498.7 сая төгрөгөөр илүү байгаа нь тариф нэмэгдэж орлого давсантай холбоотой байна.

Түрээсийн орлогын 40.0 хувь буюу 54.4 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь тайлант онд нийт 823,548.2 сая төгрөгийн 158 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,096.3 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 2,008.1 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын зөвшөөрөлгүй 39.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах

шийдвэр гаргах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам"-ын 1.2 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын жилийн төлөвлөгөөнд тухайн онд худалдан авах хөрөнгийг тодорхой нэр заан батлуулж байх зөвлөмж өгөх

Түрээслэгч байгууллагатай түрээсийн гэрээ хийхдээ сарын түрээсийн төлбөртэй тэнцэхүйц хэмжээний 7.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг урьдчилан байршуулаагүй, түрээсийн орлогыг орсон тухай бүрд ажлын 5 хоногт улсын төсөвт төвлөрүүлэлгүй, хуримтлуулан улирал бүрээр төвлөрүүлсэн, түрээсийн гэрээг цуцлахдаа гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний хугацаа дуусахад түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэж сунгуулах эсхүл цуцлах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээгүй байна. Энэ нь Түрээсийн гэрээний 3.3-д "Түрээслэгч нь гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний буюу 7,878,513.86 төгрөгийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана.", 3.6-д "төлбөр орсноос хойш ажлын 5 хоногийн дотор улсын төсөвт төвлөрүүлнэ" 5.5-д "Энэхүү гэрээний аль нэг заалтыг түрээслэгч зөрчсөн тохиолдолд барьцаа төлбөрийг буцаан олгохгүй бөгөөд түрээсийн төлбөрт тооцно. Мөн гэрээний хугацаа дуусахад түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэж сунгуулах эсхүл цуцлах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Түрээслэгчээс гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний барьцаа аван түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулах, гэрээг дүгнэж барьцаа төлбөрийг буцаан олгох болон гэрээг сунгах эсэхийг шийдвэрлэж байх зөвлөмж өгөх

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол батлагдсанаас хойш 11.2 сая төгрөгийн албан конторын тавилга болон бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 43-р тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Баяр ёслолын үйл ажиллагаанд 4.5 сая төгрөг зарцуулсан. Энэ нь Засгийн газрын 43-р тогтоолын 1.1. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд

хөрөнгө олж авах шилжүүлэх журам", ТБОНӨХБАҮХАТухай хууль, Түрээсийн гэрээний биелэлт зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 350.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 349.1 сая төгрөгийг залруулж, 1.0 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 762.3 сая төгрөгийн зөрчилд 17.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 744.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100.0 хувь, зөвлөмж 98.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	17.7	1	17.7	-	-	100.0
Зөвлөмж	2	744.6	2	723.6	-	21.0	98.0
Нийт дүн	3	762.3	3	741.3	-	21.0	99.0

/сая төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2021 оны жилийн эцсийн тооллогоор илүүдсэн бараа материал, 2022 оны зээлийн хүүгийн тооцоололд өөрчлөлт орсон эсэх, 2022 оны 4 дүгээр сард ашиглалтад орох орон сууцны ажилтнуудтай холбоотой төлбөр тооцоо дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 254.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 119.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 128.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 135.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 386.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 119.4 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- ӨДС-ийн турбин заалны барилгын 18 жил ашиглах хугацааг элэгдэл байгуулахдаа 25 жилээр тооцож элэгдлийн зардлыг 86.6 сая төгрөгөөр дутуу тооцсон;
- Гадаад томилолтын төсвийг 1.4 сая төгрөгөөр илүү тооцоолж, томилолтын урьдчилгаа олгосон;
- Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 11 аж ахуйн нэгжийн 22.1 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй, татварын и-баримт цахим хуудсанд шивүүлээгүй;
- 2021 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн дүн 9.1 сая төгрөгөөр, төлөвлөгөөний дүнг 0.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.

8.2 Төлбөрийн акт

Шатахууны зарцуулалтыг давтан тооцоолоход автомашины зарцуулах шатахууны хэмжээг зарцуулалтыг жишиг нормоос өндөр баталж, 2.2 сая төгрөгийг шатахуун илүү зарцуулсан. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

Тунгаагдсан усан санд хуримтлагдсан үнс цэвэрлэх, засварлах 128.2 сая төгрөгийн өртөгтэй ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулаагүй, гэрээ шууд байгуулсан байна. Гэрээ шууд байгуулах болсон үндэслэлээ Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 **Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт:

Хуучин сэлбэг материал худалдан борлуулсан 4.1 сая төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг цаг тухайд нь бүртгээгүйгээс үнэ өөрчлөгдсөний дараа анхан шатны баримтыг үйлдэж, зөрүү үүсгэсэн байна. Мөн хуучин сэлбэг борлуулахдаа шаардах хуудас бичиж зарлагадсан 0.3 сая төгрөгийн гүйлгээ байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын анхан шатны баримтын иж бүрдлийг үнэн зөв бүрдүүлж, санхүүгийн бүртгэлд тухай бүрд нь бүртгэж байх.

2 **Цалингийн зардалтай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас 2 ажилтан буруу үйл ажиллагаа явуулж 0.7 сая төгрөгийн зөрчил гаргасанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн, сахилгын шийтгэлтэй ажилтныг тушаал дэвшүүлэн томилсон байна. Энэ нь Хөдөлмөрийн дотоод журмын 17.2.8 "Удирдах албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас ажилтан буруу үйл ажиллагаа явуулж хохирол учруулсан тохиолдолд шийдвэр гаргасан буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ", 17.1.7 "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно. Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд ажил албан тушаалд дэвшүүлэн ажиллуулах, шагнаж урамшуулахгүй", 17.1.3 "Гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд зөрчил гаргасан сарын үйл ажиллагааны үр дүнгийн шагнал олгохгүй бөгөөд олгосон тохиолдолд буруутай этгээдээр төлүүлнэ" гэсэн заалтуудтай

нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Удирдлага шийдвэрээ үндэслэлтэй боловсруулах, сахилгын шийтгэлтэй албан тушаалтныг урамшуулал, албан тушаал дэвшүүлэх байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	ӨДС-ийн турбин заалны барилгын 18 жил ашиглах хугацааг элэгдэл байгуулахдаа 25 жилээр тооцож элэгдлийн зардлыг 86.6 сая төгрөгөөр дутуу тооцсон.	НББОУС 16-ийн 50,51 р зүйл "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна"	1	86,574.4	1	86,574.4								
2ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Гадаад томилолтын төсвийг 1.4 сая төгрөгөөр илүү тооцоолж, томилолтын урьдчилгаа олгосон байна.	Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2011 оны 188 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй	1	1,399.7	1	1,399.7								
3ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 11 аж ахуйн нэгжийн 22.1 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй, татварын и-баримт цахим хуудсанд шивүүлээгүй байна.	НББОУС 7-ийн 45 р зүйл "байгууллага мөнгө ба мөнгөтэй адилтгах бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах бөгөөд мөнгөн гүйлгээний тайлан дахь дүнг санхүүгийн байдлын тайлангийн харгалзах дүнтэй тулган тохируулж, толилуулна"	1	22,113.6	1	22,113.6								
4ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	2021 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн дүн 9.1 сая төгрөгөөр, төлөвлөгөөний дүнг 0.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	Засгийн газрын 2020 оны 217 тоот тогтоол "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй	1	9,319.0	1	9,319.0								
5ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Шатахууны зарцуулалтыг давтан тооцоолоход автомашины зарцуулах шатахууны хэмжээг	Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр	1	2,204.5			1	2,204.5						

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			зарцуулалтыг жишиг нормоос өндөр баталж, 2.2 сая төгрөгийг шатахуун илүү зарцуулсан.	хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг" заалтыг хэрэгжүүлээгүй												
6ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Тунгаагдсан усан санд хуримтлагдсан үнс цэвэрлэх, засварлах 128.2 сая төгрөгийн өртөгтэй ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулаагүй, гэрээ шууд байгуулсан байна. Гэрээ шууд байгуулах болсон үндэслэлээ Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна.	ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх.	1	128,191.9					1	128,191.9				
7ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Хуучин сэлбэг материал худалдан борлуулсан 4.1 сая төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг цаг тухайд нь бүртгээгүйгээс үнэ өөрчлөгдсөний дараа анхан шатны баримтыг үйлдэж, зөрүү үүсгэсэн байна. Мөн хуучин сэлбэг борлуулахдаа шаардах хуудас бичиж зарлагадсан 0.3 сая төгрөгийн гүйлгээ байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"	1	4,361.5								1	4,361.5	
8ДЦС-3 ТӨХК		АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас 2 ажилтан буруу үйл ажиллагаа явуулж зөрчил гаргасанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн, сахилгын шийтгэлтэй ажилтныг тушаал дэвшүүлэн томилсон байна.	Хөдөлмөрийн дотоод журмын заалтыг баримтлан, тушаал шийдвэр гаргахдаа хяналт хийж анхаарч байх.	1	757.3									1	757.3
ДҮН					8	254,921.9	4	119,406.7	1	2,204.5	1	128,191.9			2	5,118.8
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ДЦС-3 ТӨХК	АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2,096.3 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 2,008.1 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах.	1	4,104,434.5									1	4,104,434.5
2	ДЦС-3 ТӨХК	АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын зөвшөөрөлгүй 39.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам"-ыг мөрдөн ажиллах зөвлөмж өгөх	1	39,402.7									1	39,402.7
3	ДЦС-3 ТӨХК	АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Түрээслэгч байгууллагатай түрээсийн гэрээ хийхдээ сарын түрээсийн төлбөртэй тэнцэхүйц хэмжээний 7.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг урьдчилан байршуулаагүй, түрээсийн орлогыг орсон тухай бүрд ажлын 5 хоногт улсын төсөвт төвлөрүүлэхийг хуримтлуулан улирал бүрээр төвлөрүүлсэн, түрээсийн гэрээг цуцлахдаа гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний хугацаа дуусахад түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэж сунгуулах эсхүл цуцлах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээгүй байна.	Түрээсийн гэрээний хэрэгжилтийг хангаж, гэрээний заалтуудыг мөрдөн ажиллах зөвлөмж өгөх	1	7,878.5									1	7,878.5
4	ДЦС-3 ТӨХК	АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол батлагдсанаас хойш 11.2 сая төгрөгийн албан конторын тавилга болон	Засгийн газрын 43-р тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр	1	11,238.3					1	11,238.3				

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.	бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн												
5	ДЦС-3 ТӨХК	АХГ-2022/87/НА-СТА-ТӨА	Баяр ёслолын үйл ажиллагаанд 4.5 сая төгрөг зарцуулсан.	Засгийн газрын 43-р тогтоолын 1.1. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчих заалтыг хангаж ажиллаагүй	1	4,474.0					1	4,474.0				
ДҮН					5	4,167,428.0					2	15,712.3			3	4,151,715.7
НИЙТ ДҮН					13	4,422,349.9	4	119,406.7	1	2,204.5	3	143,904.2			5	4,156,834.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 424/Н.О.150055
АХГ-2022/87/НН-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баяр ёслолын үйл ажиллагаанд зориулан 4,474,001.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг орлон гүйцэтгэгч О.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.ГАЖИДМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-97.Docx

0010831178



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 425/А0150055
АХГ-2022/83/КА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тунгаагдсан усан санд хуримтлагдсан үнс цэвэрлэх, засварлах 128,191,900.00 төгрөгийн өртөгтэй ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад нээлттэй тендер зохион байгуулаагүй, гэрээ шууд байгуулсан байна. Гэрээ шууд байгуулах болсон үндэслэлээ Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нээлттэй тендер шалгаруулаагүй, гэрээ шууд байгуулсан үндэслэлээ Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг орлон гүйцэтгэгч О.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.ГАЖИДМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20-Bichig_Khereg_Alban_Shaardlaga_2022-0315_Auditin_2_Gazar-99.Docx

0010831182



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 92 /А0150055
АХГ-2022/87/НА-СТА-Т0А

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автомашинны шатахуун зарцуулалтын хэмжээг жишиг нормоос өндөр баталж, 2,204,471.00 төгрөгийн шатахуун илүү зарцуулсан.


Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү зарцуулсан шатахууны 2,204,471.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг орлон гүйцэтгэгч О.Энхбаяр нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.ГАЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 426/А0150055
АХГ-2022/87/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол батлагдсанаас хойш 11,238,318.18 төгрөгийн албан конторын тавилга болон бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг орон гүйцэтгэгч О.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.ГАЖИДМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

«10.10.2020» Бичиг Хөргөгч/Alban.Shaardlaga/2022/0315 Auditin 2 Газар-98.Docx

0010831180

